## АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

## А.ТАНИЛЦУУЛГА

<table>
<tr><td colspan="2">1.Байгууллагын нэр:<br>“Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ</td><td colspan="2">2.Нэгжийн нэр:</td></tr>
<tr><td colspan="2">3.Ажлын байрны нэр:<br>Лифтчин</td><td>3.1. Албан тушаалын ангилал:<br>Техникийн гүйцэтгэх ажилтан</td><td>3.2. Албан тушаалын зэрэглэл:</td></tr>
<tr><td colspan="2">4. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр:<br>Газрын дарга,<br>Ерөнхий инженер, Дулааны инженер</td><td>4.1. Албан тушаалын ангилал:<br>Удирдах,<br>Мэргэжлийн</td><td>4. Албан тушаалын зэрэглэл:</td></tr>
<tr><td>5. Ажлын байрны шууд харъялан удирдах албан тушаал:</td><td colspan="2">5.1. Албан тушаалын нэр:</td><td>5. Албан тушаал эрхлэгчдийн тоо:</td></tr>
</table>

## Б. ЧИГ ҮҮРЭГ

<table>
<tr><td>1. Ажлын байрны зорилго</td><td colspan="2">Хотхоны 901, 902, 813 дугаар байрны цахилгаан шатны ашиглалт үйлчилгээ, өдөр тутмын хэвийн ажиллагаа, доторх цэвэрлэгээ, техникийн үйлчилгээг хариуцан, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар гэрээний дагуу засварын ажлыг гүйцэтгүүлж, хяналт тавих, удирдлагын үнэн зөв мэдээллээр хангах, оршин суугч иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлж ажиллах.</td></tr>
<tr><td colspan="2">2. Ажлын байрны үндсэн зорилт</td><td>2.1Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td></tr>
<tr><td colspan="2">1. Байгууллагын цахилгаан шатны ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангуулах<br>2. Цахилгаан шатанд хийгдэх техник үйлчилгээ,тавигдах шаардлага, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах<br>3. Цахилгаан шатны ашиглалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, бусад холбогдох стандартуудыг судалж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах<br>4. Оршин суугч иргэдийг цахилгаан шатаар зорчих, ашиглах талаар мэдлэгтэй, болгоход анхаарч мэдээлэл хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах.</td><td>1. Цахилгаан шатны техникийн аюулгүй байдал хангагдаж, тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.<br>2. Цахилгаан шатыг аюулгүй ашиглах дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.<br>3. Шинээр ашиглалтанд орж буй барилга орон сууцанд суурилагдаж буй цахилгаан шатны ашиглалтын горим, мөрдөгдөж буй норм дүрмийн талаарх мэдээлэлтэй болно.<br>4. Иргэд, оршин суугчдыг цахилгаан шатыг зориулалтын дагуу ашиглах мэдлэгийг дээшлүүлнэ</td></tr>
</table>

| 3. Ажлын байрны гол үйл ажиллагаа | 3.1 Хугацаа хуваарь |
|---|---|
| <u>Ажлын байрны 1-р үндсэн зорилтын хүрээнд</u><br>1.1 Цахилгаан шатны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, техник үйлчилгээг цаг тухайд нь гэрээт мэргэжлийн байгууллагаар хийлгэх<br>1.2 Цахилгаан шат, машины өрөөний цэвэрлэгээг хариуцан ажиллах<br>1.3 Хотхоны оршин суугчдыг цахилгаан шатаар аюулгүй зорчих нөхцөлөөр хангах<br>1.4 Цахилгаан шатны гэрэлтүүлгийн найдвартай ажиллагааг хангах, шинэчлэх | 40% |

| | |
|---|---|
| **Ажлын байрны 2-р үндсэн зорилтын хүрээнд**<br>2.1 Авар ослын үед ажиллах шуурхай ажиллагааны бэлэн байдлыг хангуулж зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авч, оршин суугчдыг осол авааргүй зорчих нөхцлийг бүрдүүлэх<br>2.2 Цахилгаан шатнуудад жил бүр холбогдох байгууллагаар техникийн магадлал хийлгэх<br>**Ажлын байрны 3-р үндсэн зорилтын хүрээнд**<br>Цахилгаан шатны ашиглалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, бусад холбогдох стандартуудыг судалж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах.<br>3.1 Цахилгаан шатны ашиглалт, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, бусад холбогдох стандартуудыг судалж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.<br>3.2 Цахилгаан шатанд гарсан доголдол гэмтлийг цаг тухай бүр удирдлагад танилцуулж холбогдох арга хэмжээг авч эвдрэл гэмтлийг богино хугацаанд засварлах.<br>**Ажлын байрны 4-р үндсэн зорилтын хүрээнд**<br>4.1 Хотхоны оршин суугч иргэдэд цахилгаан шатаар аюулгүй зорчих, ашиглалтын дүрэм журмын талаар мэдлэг олгох чиглэлээр зурагт хуудас, плакат, зөвлөмж боловсруулан мэдээлэл хүргэх арга хэмжээг зохион байгуулах.<br>4.2 Цахилгаан шатны техникийн хүчин чадал, магадлал хийлгэсэн хугацаа, яаралтай дуудлага өгөх утас зэрэг мэдээллийг нэгтгэсэн металл санамжийг шатанд байршуулж, аюулгүй ажиллагааны горимыг мөрдүүлж ажиллах.<br>**Ажлын байрны зорилтын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:**<br>- Цаг үеийн нийгмийн болон бусад ажлуудад оролцох<br>- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай сайн биелүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол тайлагнах<br>- Байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдах<br>- Үйлчилгээг үзүүлэхдээ иргэдэд соёлтой, ёс суртахуунтай, хүнд суртал гаргахгүй эелдэг боловсон харилцах<br>- Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалт, сахилга хариуцлагыг хууль журмын хүрээнд мөрдөж ажиллах,<br>- Шаардлагатай үед цахилгаанчныг орлож ажиллах | 30%<br>15%<br>15% |

**В. ТАВИГДАХ ШААРДЛАГА**

| **1. Ажлын байранд тавигдах шаардлага** | **1.1 Ерөнхий шаардлага** | **Үзүүлэлт** | **Чухал шаардлагатай** | **Шаардлагатай** |
|---|---|---|---|---|
| | | **Боловсрол** | Дээд, тусгай дунд | |
| | | **Мэргэжил** | Лифтчин, цахилгаанчин | |
| | | **Мэргэшил** | Лифтчин, цахилгаанчны мэргэжлийн зэрэгтэй байх | Техник үйлчилгээг бие даан хийх чадвартай байх |
| | | **Туршлага** | Тухайн мэргэжлээр 1-ээс доошгүй жил ажилласан. | - |
| | | **Ур чадвар** | • Багаар ажиллах чадвартай байх,<br>• Хүнтэй харьцах чадвартай байх, | Зохих түвшинд цахилгааны схем, техникийн зааврыг уншиж ойлгох чадвар эзэмшсэн байна. |
| | **1.2 Тусгай шаардлага** | | • Ёс зүйн хэм хэмжээг сахих | |

## Г. ХҮЧИН ЗҮЙЛС

| 1. Ажлын байрны харилцах субъект | |
|---|---|
| **1.1 Байгууллагын дотор талд байгаа** | **1.2 Байгууллагын гадна талд байгаа** |
| Газрын дарга, ерөнхий инженер, | - Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага<br>- Иргэд, оршин суугчид |

| | | |
|---|---|---|
| **2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага** | Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж,“Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ын дүрмийн дагуу эрх зүйн холбогдолтой аливаа асуудлаар газрын даргын өмнө хариуцаж, ажил үүргээ биелүүлээгүй тохиолдолд хууль журмын дагуу хариуцлага хүлээнэ. Ажлын хариуцлага алдсанаас учруулсан эд хөрөнгийн хохирлыг бүрэн хариуцна | |
| **3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл** | **3.1 Санхүүгийн** | Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал |
| | **3.2Биет хөрөнгийн** | • Албан өрөөний тавилга<br>• Багаж хэрэгсэл |
| | **3.3 Хүний** | **1** |
| | **3.4 Бусад** | **-** |
| **4. Ажлын байрны нөхцөл** | **4.1Ердийн нөхцөл** | Ажлын хэвийн орчин нөхцөл байдалд ажиллана. |
| | **4.2 Онцгой нөхцөл** | Шаардлагатай үед илүү цагаар ажиллах, хотхоны гадаад дотоод цэвэрлэгээ, тохижолтын ажилд идэвхитэй оролцох. |

## Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажилтан** | **Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан** |
|---|---|
| **Албан тушаалын нэр:**<br><br>ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН<br><br>................................ Г.БААТАРХҮҮ<br><br>2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр | **Албан тушаалын нэр:**<br><br>“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА<br><br>............................... Ц.ОТГОНБАТ<br><br>2017 оны .... дугаар сарын ... -ны өдөр |